




Христийн Бие болон “дээш чиглэсэн дуудлага” нь

Өмнөх хэдэн нийтлэлд бид Паулд даатгагдсан сайн мэдээний зарим онцлогийг авч үзээд Петрт даатгасан, Хаант улсын тухай сайн мэдээнээс үнэн ялгаатай болохыг нь олж харсан. Тухайлбал: Паулын зарласан сайн мэдээнд Христийн загалмайн тухай ойлголт илүү гүнзгий бөгөөд бахархууштай. Загалмайн үндсэн дээр өгөгдсөн хайр ивээл хэм хэмжээгүй, итгэгчид уучлал өршөөл авахын оронд зөвтгөгдөөд зогсохгүй, Ертөнцийн Эзэнтэй эвлэрдэг. Учир нь, тэд Христтэй хамт дахин төрөөгүй харин дахин амилсан шив шинэ бүтээлд тооцогддог. Шинэ бүтээл болсон итгэгч хуучин бүтээлд хамрагддаг махбодод түшиглэдэггүй. Тэд хэнийг ч, өөрийгөө ч гэсэн, Христийг ч гэсэн, махбодийн дагуу үздэггүй байхыг сурна.



Энэ нийтлэлд бид шинэ бүтээлийн тухай хэмжээлшгүй хайр ивээлт мэдээг хүлээж авсан хүмүүс болон онцгой тэнгэрлэг хувь заяагийнх нь тухай авч үзнэ.

Петр Израилын эрчүүдэд үгээ хэлж (Үйлс 2:14), үндэстнүүдийн дунд тархсан израилчуудад захидал бичсэн (1 Петр 1:1). Есүсийн төрсөн дүү Иаков мөн адил захидлаа “харьд тархсан арван хоёр овогт” бичив (Иаков 1:1).




Харин Паул захидлуудаа ер нь “ариун хүмүүс”-т хандуулжээ. Эсвэл тухайн газарт буй “Бурханы (доторх) чуулган”-д бичсэн.¹

“Бурханы сүм чуулган Ариун Сүнс бууж ирсэн Пентекостын тэр өдөр эхэлсэн биз дээ. Үндэстнүүдээс итгэсэн хүмүүс Бурханы тэр л чуулганд нэмэгдсэн” гэж та бодож магад.

Анх Есүс Петр буюу хадан дээр чуулганаа босгоно гэж хэлсэн (Матай 16:18; Эфэс 2:20, Илчлэл 21:14 үзнэ үү). Иймээс Петр Пентекост өдөрт анхны сургаалаа заагаад үр дүнд нь 3000 хүн Есүст итгэгчдийн тоонд “нэмэгджээ” (Үйлс 2:41). Гэхдээ энэ бол Ертөнцийн Эзэний анхны Сүм чуулган байгаагүй нь мэдүүштэй.

“Чуулган” (сүм цуглаан) гэсэн үгийг товч судлахад грекээр *эκκλησία* (G1577) гэдэг энэ үг “дуудаж гаргасан нь” гэсэн үндсэн утгатай. Грекчүүдийн дунд гэрээс нь дуудаж цуглуулсан иргэдийн чуулганыг “эκκλησία” гэдэг байв. Сонирхолтой нь, тус үг грек нийгмийн энэ утгаар Үйлс 19-д гардаг. МЭӨ 550 онд баригдсан, Ефес дэх Артемис дарь эхийн сүм нь эртний ертөнцийн долоон гайхамшгийн нэг байв.

1 Аруин хүмүүст: Ром 1:7; 1 Коринт 1:2; 2 Коринт 1:1; Эфэс 1:1; Филиппой 1:1; Колоссай 1:2. Бурханы (доторх) чуулганд: 1 Коринт 1:2; 2 Коринт 1:1; 1 Тесалоник 1:1; 2 Тесалоник 1:1. Сонирхолтой нь, “Бурханы чуулган” гэсэн хэллэг анх Үйлс 20:28-т гардаг бөгөөд Паулын Эфэс хотод байгуулсан сүм чуулганыг хэлсэн.



Деметр гэгч мөнгөний дархан тус алдарт сүмийн бяцхан хуулбарыг урлан хийдэг байв. Гэтэл Паулын зарладаг мэдээнээс болж хүмүүс бүтээгдэхүүнийг нь авахаа больсон. Үүнд арга хэмжээ авахаар Деметр бусад дархчуудыг дуудаж хуралдуулсан. Тэдний үймээн дэгдээсэн цуглааныг бас “чуулган” буюу “экклэсиа” гэж нэрлэсэн байна (Үйлс 19:32; АБ: “цугласан олон”). Эцэст нь хотын захирагч хилэгнэсэн олныг тайвшруулаад, асуудлыг нь “хууль ёсны экклесиа”-гаар шийдвэрлэнэ гэжээ (Үйлс 19:39; АБ: “хурал”).


Ертөнцийн Эзэний Чуулган бол «Хуучин гэрээ»-ний үед ч байдаг байсан. Тухайлбал: Египетээс дуудаж гаргасан “цөл дэх чуулган” буюу Израилын ард түмэн (Үйлс 7:38). «Хуучин гэрээ»-ний “Септуагинта” хэмээх грек орчуулганд “экклэсиа” гэдэг үг мөн гардаг: “Израилийн даяар чуулган” (Дэд хууль 31:30; Иошуа 8:35 г.м.).



Библид “чуулган” гэсэн үг гарахаар яг ямар чуулганыг ярьсан байгаа, ямар хүмүүс хаанаас “дуудаж гаргасан”-ыг анхаарч ойлгох хэрэгтэй.

“Христийн Бие” гэдэг чуулган бий болсон нь

Энэ бүхнээс дүгнэхэд Ертөнцийн Эзэнд ганц биш, хэд хэдэн чуулган байдаг. Анх Египетээс дуудаж гаргасан ард түмэн Түүний чуулган байсан бол Христийн үеэр Түүнд итгэсэн иудейчүүдийг ард олны дундаас дуудан гаргасан нь чуулган нь болсон.



Дээр нь Паулын зарласан сайн мэдээнд итгэсэн үндэстний хүмүүс өөр өөрсдийн нийгмээсээ дундаас дуудагдан, орон нутгын олон чуулганыг бүрдүүлсэн. Гэхдээ тэдний орон нутгын сүм чуулганууд хамтдаа нэгэн Чуулганыг бүрдүүлдэг. Энэ Чуулган онцгой нэртэй. Тухайлбал (Эфэс 1:22-23):
“Бурхан бүх юмсыг [Христийн] хөл доор захируулж, Түүнийг чуулганд бүх юмсын дээрх Тэргүүн болгож өгөв. Чуулган нь Түүний бие...”

Эндээс харахад тус чуулганыг “Христийн Бие” гэдэг бөгөөд Христ Есүс мэдээж Биеийнхээ Толгой. Паулын захидлаас өөр хаана ч “Христийн Бие”-ийн



Христийн Бие ба “дээш чиглэсэн дуудлага” нь • 5

тухай Библид гардаггүй учраас энэ цол маш содон. (Жич: зарим хүн “христийн биенүүд” гэж ярихыг сонссон. Нэгэнт Христ цорын ганц учраас ганцхан Биеийг л толгойлох нь жам. Нөгөө талаар Христийн Бие ганц л тэргүүнтэй байх нь ч ойлгомжтой.)

Тэгэхээр «Шинэ гэрээ»-нд Христийн дуудаж гаргасан хоёр янзын чуулган байдаг нь харагдаж байна. Энэ хоёр бүлэг хүмүүст хоёр янзын сайн мэдээ ирсэн билээ. Яагаад тэр вэ? гэвэл тэдний дуудлага болон хувь заяа нь өөр өөр учраас тэр.

Хоёр чуулганы хоёр дуудлага

Израилын чуулганы дуудлага Мосегийн үеэс эхлэн тодорхой. Үүнд: “Та нар Миний тусгаар ариун





үндэстэн, тахилчдын хаант улс байх болно” (Гэтлэл 19:6).

Тэр хаант улс бол Есүсийн зарладаг байсан “тэнгэрийн хаант улс”. Хэрэв иудейчүүд Түүнд эсвэл Түүний элч нарт итгэхсэн бол ойртож ирсэн Хаант улс тэр үед байгуулагдан хамаг газар дэлхийг хамруулах байсан. Гэвч ихэнх иудейчүүд хаанчлалын тухай сайн мэдээнд ч итгэсэнгүй, Есүсийг Машиах Аврагч гэж ч хүлээж авсангүй. Харин ч тэд эхлээд Есүсийг загалмай дээр хороолгон, дараа нь Стефаныг чулуугаар шидэн алсан. Стефан грекээр “ялалтын титэм” гэсэн утгатай. Иудейчүүд Хааны хамт Хаант улсыг голсон учраас ойртон байсан Хаант улс байгуулагдах нь хойшлогдсон.

Тэглээ ч гэсэн Есүст итгэсэн еврейчүүдэд өнөөх дуудлага нь хэвээрээ. Ертөнцийн Эзэний дуудлага буцалтгүй билээ (Ром 11:29). Тус дуудлагыг Петр тод үгээр баталсан. Үүнд: “Та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм” (1 Петр 2:9).²

Иохан бас энэ дуудлагаа дурдсан. Үүнд: “...биднийг хаанчлал төдийгүй, Бурхан ба Эцэгийнхээ төлөөх тахилч нар болгосон Түүнд алдар хийгээд ноёрхол

2 Зөвхөн иудейчүүд (=Иуда овгийнхон) зогсохгүй, хамаг Израил энэ дуудлагаа биелүүлэх ёстойг Петр эш үзүүлэгч Хосеаг иш татсанаар илэрхийлжээ. “Урьд нь ард түмэн биш байсан”, “өршөөлийг хүртээгүй байсан” хүмүүс бол Ертөнцийн Эзэний “салж явуулсан” Израилын арван овог (Хосеа 1-2; Иеремиа 3:8).



нь үеэс үед байх
болтугай. Амен. ”
(Илчлэл 1:6).



Хаант улс хойшлогдох
нь тодорхой болсны
дараа Их Эзэн Паулыг
дуудаж, бусад
үндэстнүүдэд
илгээсэн. Паулын нэр
“пауз авах” гэсэн үйл
үгнээс гаралтай. Израилд зориулсан
төлөвлөгөөндөө Их Эзэн завсарлага авсныг нэрээр
нь хүртэл илэрхийлсэн. Паул Христийн Биеийн
анхны гишүүн.

Христийн Биеийн дуудлага өөр бөгөөд үнэхээрийн
гайхаш төрүүлмээр. Библийн анхны үг бол энэ:
“Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ” (Эхлэл 1:1).
Тэгээд байнга газар дэлхийн тухай гарна. Есүс
Израилчуудад лав “тэнгэрийн юмсыг” яриагүй
(Иохан 3:12). Паулыг л дуудахдаа Их Эзэн тэнгэрийн
тухай ярьдаг болсон.

Юу гэвэл, Христийн Биеийнхний “иргэний харьяалал
тэнгэрт байгаа”. Тийм учраас дуудлага маань “дээш
чиглэсэн” байна (Филипой 3:20,14). Ертөнцийн Эзэн
“тэнгэрлэг оршихуй дахь [эсвэл: тэнгэрийн дээрх
улсуудын дунд] алив сүнслэг ерөөлөөр биднийг
ерөөжээ” (Эфэс 1:3).³

3 “Тэнгэрлэг оршихуй” гэж орчуулсан үг (G2032) “тэнгэр дээр” гэсэн
үндсэн утгатай. Эфэсийн дээрх гурван ишлэлд тус бүртээ “тэнгэр



Учир нь, “Христ Есүс дотор биднийг Түүнтэй хамт амилуулж, хамт тэнгэрлэг оршихуйд [хаан сэнтий дээр нь] суулгасан” (Эфэс 1:20, 2:6).

Бид одоохондоо төрсөн газар дэлхий дээрээ амьдарсан хэвээр ч, Паул дээрх үгийг өнгөрсөн цагаар бичсэн нь ирээдүйг маань дэндүү баталгаатай болохыг илэрхийлсэн хэрэг.⁴

Цаг нь ирэхээр Их Эзэн “дорд биеийг маань Өөрийнхөө цог жавлант биетэй адил болгон өөрчлөн” хувиргах болно (Филипой 3:21).

“Тэнгэрлэг хүний дүрийг өмсөх” тэр өдөр бид “агаарт Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөж [шүүрэгдэж], тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно” (1 Коринт 15:49; 1 Тесалоник 4:17; 2 Тимот 4:18). Дээр үед Есүс тэнгэр өөд одсон шиг Түүний Биеийн гишүүд болох бид мөн адил тэнгэрийн дээрх улс рүү явна. Учир нь, бид тэнд хийх ажилтай. Энэ нь “Христ Есүс дотор бидэнд хандсан Түүний хайр ивээлийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд үзүүлэх” зэрэг үйлчлэлийг



дээрхүүдийн дунд” гэсэн хэлбэрээр гарсан нь “тэнгэр дээр амьдардаг улсуудын дунд” гэсэн утгатай.

- 4 Үүнийг “зөгнөлийн өнгөрсөн цаг” гэдэг. Ертөнцийн Эзэн “байхгүйг байгаагаар дуудагч”, өөрөөр хэлбэл хараахан болоогүй зүйлийг аль хэдийн бүтсэн мэтээр ярьдаг (Ром 4:17). Учир нь, бүтэхийг нь Тэр Өөрөө болгоно.



багтаах болно (Эфэс 2:6-7, Колосас 1:18-20).

Дуудагдсан нь ба сонгогдсон нь

Хаант улсад орох израилчуудын тухай Есүс “дуудагдсан нь олон ч сонгогдсон нь цөөхөн” гэжээ (Матай 22:14)⁵. Сонгогдсон нь “Бурханы Израил” бөгөөд “Хурганы эхнэр болох сүйт бүсгүй”-г бүрдүүлнэ (Галат 6:16; Илчлэл 21:9).


Сонгогдохын тулд итгэгч хүн “үхэл хүртэл үнэнч байх” ёстой (Илчлэл 2:10). Тийм хүн “амийн титэм” авна. Өөрөөр хэлбэл, Хаант улсад орж захирахын тулд дахин амилах болно. Харин “халуун ч биш, хүйтэн ч биш, бүлээн” үйлстэй хүнийг Есүс “амнаасаа нулимж гаргах” аюултай (Илчлэл 3:15-16). Тийм хүн Хаант улсад орно гэж бодох хэрэггүй.⁶

- 5 Зөвхөн “итгэлийн хүмүүс нь Абрахамын хөвгүүд” учраас “Израиль удамтай хүн бүр Ертөнцийн Эзэний хүн болно гэсэн үг байхгүй билээ” (Галат 3:7; Ром 9:6, ББ).
- 6 Эрт дээр үед Ертөнцийн Эзэн Синай уулан дээр Израилтай гэрээ хийснээ тус ард түмнийг Өөрийн эхнэрээ болгосон гэж дүрслэн ярьдаг. Израилчууд тус гэрээг олонтаа зөрчиж, өөр бурхдыг шүтэн, ёс суртахуунгүй аашилж, Их Эзэнд үнэнч бусаар хандсны төлөө тэднийг “завхайрсан эхнэр” гэж буруутгаад эцэст нь салсны баталгаа бичиж өгөөд явуулсан (Иеремиа 3:6, 8, 20; 31:31-32; Езекиел 16). Гэсэн хэдий ч Их Эзэн Израйльтай шинэ гэрээ хийхээ бас амласан (Езекиел 16:60-63, Иеремиа 31:31-34). Иймд тус ард түмнээс Есүс ба Петрийн зарласан мэдээнд итгэж батлуулсан хүмүүс “Хурганы сүйт бүсгүй”-д хамрагдана. Иохан энэ “бүсгүй”-г тэнгэрээс бууж ирэх Шинэ Иерусалим хот болохыг



Дуудагдах ба сонгогдох тал дээр Паул Есүсийн үгнээс яг эсрэг зүйл бичсэн. Паулын үг Хаант улсад орох тухай биш, Христийн Биед хамрагдах тухай учраас тэр. Тухайлбал: Ертөнцийн Эзэн “урьдаас тогтоосон [=сонгосон] хүмүүсээ дуудсан, дуудсан хүмүүсээ зөвтгөсөн, зөвтгөсөн хүмүүсээ алдаршуулсан” юм (Ром 8:30). Анх сонгогдсон тэр хүмүүс мөн дуудагдах болно. Ертөнцийн Эзэн тэдэнд итгэл хайрладаг учраас тэд Түүнийг дуудахаар зайлшгүй харуи өгөх агаад энэ замаар олсон авралаа эргээд алдана гэж байхгүй.

“Христийн Бие”-д хамрагдсан итгэгч Тэргүүнтэйгээ хувь заяа нэг учраас тэр. Ямар ч бие махбод толгойгоо дагадаг шиг Христийн Бие ч Тэргүүнээ заавал дагах ёстой. Тиймээс ч бид Христтэй хамт загалмай дээр нас бараад хамт оршуулагдаад зогсохгүй, бас Түүнтэй хамт дахин амилсанд тооцогддог (Ром 6:3-8). Энэ замаар бид цоо “шинэ бүтээл” болсон (2 Коринф 5:17). Христтэй ийм дотноор нэгдсэн байхыг Паул “Христийн дотор” гэсэн өвөрмөц хэллэгээр илэрхийлдэг.



Христийн Бие бол Бурханы сүм

харсан (Илчлэл 21:2).

“Христийн бэр”, “Христийн сүйт бүсгүй” гэх мэтийн хэллэг Библиэс олдохгүй бөгөөд Паул хаана ч сүйт бүсгүйн тухай бичдэггүй (G3565).



Христийг Ертөнцийн Эзэн Ариун Сүнсээр тосолсон учраас “Христ дотор” буй хүн мөн адил Ариун Сүнсээр “тослогдсон” (G5548; “христ” гэдэг нь “тослогдсон нэгэн” гэсэн утгатай билээ; Лук 4:18; Үйлс 4:27; 2 Коринт 1:21).

Улмаар, Христ доторх итгэгч “золилтын өдрийн төлөө” Ариун Сүнсээр “тамгалуулсан” (G4972; 2 Коринт 1:21-22; Эфэс 1:13, 4:30; Иохан 6:27).

Ертөнцийн Эзэний тамгаа дарсан хүн Түүнд алдагдана гэж байхгүй, аврагдах өдрөө заавал үзнэ. Үүний баталгаагаар Тэрээр Ариун Сүнсээ бидэнд “барьцаа болгон өгсөн”, өөрөөр хэлбэл, бидэнд өгсөн Ертөнцийн Сүнс “бидний өвийн батлан даагч болдог” (G728; 2

Коринт 1:22; 2 Коринт 5:5; Эфэс 1:14). Нэгэнт

Ертөнцийн Эзэний Сүнс Христийн Биеийнхний “дотор оршдог” (G3611) учраас бие махбод нь “Бурханы сүм” (G3485; “сүм” гэсэн нь Иерусалим хот



дахь сүмийн өргөө шиг Ертөнцийн Эзэний орших газрыг хэлнэ). “Бурханы сүм бол ариун” (Ром 8:9,11; 1 Коринт 3:16-17). Есүсийг энэ дэлхий дээр алхаж явахад бие махбод нь мөн адил Ертөнцийн Эзэний орших сүм байв (Иохан 2:19-21).



Есүсээс Ариун Сүнс хэзээ ч авагдахгүйн адил Түүний Биенээс ч Ариун Сүнс хэзээ ч салахгүй. Тийм ч учраас Христийн Биеийнхэн бид эхнээс нь “ариун хүмүүс” гэдэг. Библийн хэллэгээр газар, уул, сав, мах, өдөр зэрэг юм “ариун” байх нь “Ертөнцийн Эзэний онцгой хэрэглээнд зориулж тусгаарлагдсан” гэсэн утгатай

(Н6942). Их Эзэн эрт дээр үед Израилд хэлэхдээ, “ИАВЭ Би тусгаар ариун учраас та нар Миний тусгаар ариун ард түмэн байна. Би та нарыг Өөрийнх



болгохын тулд эдгээр үндэстнээс тусгаарлан заагласан юм” (Хууль 20:26).

Яг үүнчлэн Их Эзэний Ариун Сүнс Өөрөө Паулыг онцгой ажилд нь зориулж еврей итгэгч нараас “тусгаарласан” (G873; Үйлс 13:2). Паулын үйлчлэлээр Христийн Биеийн гишүүн болсон хүмүүс Ертөнцийн Эзэний онцгой ажилд зориулагдсан учраас “ариун” буюу “тусгаарлагдсан” мөн (1 Коринф 1:27-28).

Энэ нь бидний хийдэг сайн үйлсээс шалгаалахгүй нь мэдээж. “Тэр биднийг ажил үйлсээр маань бус,



харин Өөрийнхөө зорилго болон өнө мөнхөөс Христ Есүс дотор бидэнд соёрхсон нигүүлслийн дагуу аварч ариун дуудлагаар дуудсан юм” (2 Тимот 1:9). Харин ч Ертөнцийн Эзэн ялангуяа тэнэг мунхаг, хүчин мөхөс, дорд дорой, бусдад гологдсон хүмүүсийг сонгох дуртай. Христийн Биеэр хүн бидний мэргэн ухаан юмуу хүч чадал биш, харин Түүний л хүч чадал ба мэргэн ухаан харагдах ёстой учраас тэр (2 Коринт 12:9; Эфэс 3:10). Бид лав Христийн Биед орсондоо өөрөөрөө сайрхаж чадахгүй.

Христийн Бие Христэд хамгаас ойр

Христийн Биеийн гишүүн байх нь санаанд багтамгүй гайхалтай эрх дарх юм. Сонгогдсон израилчууд “Хурганы сүйт бүсгүй”-г



бүрдүүлнэ. Сүйт бүсгүй нь Есүстэй маш ойр дотно учраас олон итгэгч тэр Бүсгүйд хамрагдахыг хүсдэг. Гэхдээ хайрлагдсан Сүйт Бүсгүйгээс ч илүү ойр дотно нь Түүний Бие юм!

Та бод доо: Бид Түүнтэй Бие нэг гээч! Бид Түүний гар, хөл! Тэрээр хаашаа явна, бид тийш нь явна. Түүнтэй бид амин холбоотой учраас Түүний хувь заяа бидний ч хувь заяа болжээ. Бид Түүнтэй



хамгаас ойр дотно учраас “Тэрээр хүслийнхээ нууцыг бидэнд мэдүүлэв.” Ямар нууц вэ? гэвэл: “Энэ нь цаг дүүрэхэд [=гүйцэд болоход] тэнгэр дэх юмс ба газар дээрх бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго... Бурхан бүх юмсыг [Христийн] хөл доор захируулж...” (Эфэс 1:9-10,22).

“Бүх юмс”-ад тэнгэр ба газар дахь бүх юм орно. Бидний Тэргүүн хамаг ертөнцийг тэргүүлэх болно. Хөл бол Биеийн хамгийн доод хэсэг. Тэгвэл, Христийн Биеийн



хамгийн өчүүхэн гишүүний доор ч гэсэн Ертөнцийн Эзэн бүх юмсыг захируулахаар төлөвлөсөн гэнэ! Библид бичигдээгүй байсан бол энэ үг үнэхээрийн итгэмээргүй санагдана.

Энэ бүх шалтгаанаар Есүс Биеийнхээ гишүүнийг хэзээ ч “амнаасаа нулимж гаргах”-гүй. Харин ч “Бид итгэмжгүй байлаа ч Тэр итгэмжит хэвээр байна. Учир нь Тэр Өөрийгөө үгүйсгэж чадахгүй” (2 Тимот 2:13).

Петр ба бусад элч апостол нар нэг ч удаа “Христийн Бие” эсвэл “Христ дотор” гэсэн содон хэллэгийг ашиглаагүй. Итгэгч нар Ариун Сүнсээр “тослогдсон”, “тамгалуулсан” эсвэл “барьцаа” юмуу “батлан даагч”



авсан тухай нэг ч бичээгүй. Итгэгч хүний бие махбод “Бурханы сүм” болсон гэж бичээгүй.⁷ Еврейчүүдийн апостол элч нар хэзээ ч “тэнгэр өөд явах” тухай яриагүй, бас бичээгүй. Та хайж үзээрэй!

Еврейчүүдийн 1000 жил үргэлжлэх Хаант улс өнгөрсний дараа шинэ тэнгэр, шинэ дэлхий харснаа Иохан бичсэн (Илчлэл 20:4-7; 21:1). Гэтэл итгэгч хүн одоо ч тэр шинэ бүтээлд хамрагдсан тухай Паулаас өөр ямар ч элч апостол бичээгүй. Еврейчүүдэд амлагдсан Хаант улс, шинэчлэгдэн сэргээгдсэн газар дэлхий дээр байх боловч хуучин бүтээлд хамрагдсан хэвээр учраас тэр.

Дүгнэж хэлэхэд, еврей бус үндэстний итгэгч бидэнд зориулсан асар их хайр ивээлээр бялхсан онцгой сайн мэдээ ч бий, онцгой тэнгэрлэг хувь заяа ч бий. Христийн Биед зориулсан Загалмайн тухай сайн мэдээ нь Израилд зарласан Хаант улсын тухай сайн

7 Их Эзэн Ариун Сүнсээ еврей хүмүүс дээр “цутгахад”, өөрөөр хэлбэл Ариун Сүнсээр “баптимс хүртээхэд” Сүнс нь тэдний “дээр ирсэн” буюу “буусан” (Үйлс 2:17; 1:5,8; 11:15). Ингээд тэд “Ариун Сүнсийг бэлэг болгон авч”, улмаар Ариун Сүнсээр ахин дахин “дүүрч” байсан (Үйлс 2:38; 2:4; 4:8). Энэ нь дагалдагч нарт Есүсийг гэрчилж, үүний тулд гайхамшиг бүтээхэд хэрэгтэй хүч чадал өгсөн (Үйлс 1:8). Гэвч “Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах” байдлаар “Ариун Сүнсний хуваалцагч болсон” хүн “дараа нь урвах” боломжтой бөгөөд тэгсэн цагт түүнийг “сэргээх боломжгүй” (Еврей 6:4-6). Үүнээс харахад Ариун Сүнс еврейчүүд дээр ирсэн ч эргээд авагдах боломжтой. Тийм ч учраас Давид хаан “Ариун Сүнсээ надаас бүү аваач” хэмээн гуйсан (Дуулал 51:11).

Гэтэл Христийн Бие Тэргүүнийхээ адил “Бурханы сүм” болсон. Ариун Сүнс нэгэнт “дотор нь оршдог” бол хэзээ ч эргээд авагдахгүй учраас Давид хаан шиг гуйх хэрэггүй.



мэдээнээс өөр байгаа нь улам сайн харагдаж байна. Бидний дуудлага еврейчүүдийн дуудлагаас өөр учраас бидний хүлээж авсан сайн мэдээ ч ялгаатай байх учиртай.

Бид өөрийнхөө өвдөг, хуруу юмуу чихээ үгүйсгэж чадахгүйн адил Христ Өөрийн Биеэ үгүйсгэж чадахгүй. Тийм учраас Биеийнх нь гишүүн болсон хэнийг ч хэзээ ч Өөрөөсөө салгахгүй. Энэ нь авралыг маань үнэхээрийн баталгаатай болохыг дахин батлан харуулж байна. Бидний хувь тавилан Түүнийхтэй нягт холбогдсон. Төсөөлж чадахаас агуу их энэ хайр ивээлийх нь төлөө Түүнд талархъя! □



Дараагийн нийтлэлд бид зөвт байдлын тухай авч үзэх болно. Библид олон зөвт хүмүүс гардаг. Тэгсэн ч гэсэн “зөвт хүн алга” гэсэн үг ч бий. Бид хэрхэн зөвт тооцогдох тухай авч үзнэ.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.



Христийн Бие ба “дээш чиглэсэн дуудлага” нь • **17**

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org